МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 29 өдөр Дугаар А/330 Мөрөн сум

"Бүх нийтээр мод тарих өдөр"-ийг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63, 2021 оны 58 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Тэр бум мод" үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын санаачилсан "Мод тарьж ногоон суварга босгоё" аяны хүрээнд намрын "Бүх нийтээр мод тарих өдөр"-ийг 2022 оны 10 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсугай.

2. Зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. "Бүх нийтээр мод тарих өдөр"-ийн төлөвлөгөө боловсруулж, мод тарих, тарьсан модыг бүртгэлжүүлж, жилийн турш арчилж хамгаалах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (П.Ариунбат)-д даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр
сарын 29-ний өдрийн А/330 дугаар
захирамжийн хавсралт

"ТЭР БУМ МОД" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН, "МОД ТАРЬЖ НОГООН СУВАРГА БОСГОЁ" АЯН, НАМРЫН "БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ӨДӨР"-ИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтарч ажиллах байгууллага	Зардал сая.төг	Хүрэх үр дүн
1. Аймгийн хэмжээнд зохион байгуулах ажил						
1	"Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийг Хөвсгөл аймагт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган сумдад хүргүүлж ажлыг удирдан зохион байгуулах	2022-10-01	Байгаль, орчин аялал жуулчлалын газар /БОАЖГ/	БОАЖГ, Салбар ажлын хэсгүүд	-	"Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийн хүрээнд аймагт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлууд хэрэгжсэн байна.
2	Өөрийн аймагт тарьж ургуулсан төв суурин газрын цэцэрлэгжүүлэлтэнд нийлүүлэх боломжтой тарьц суулгацны төрөл зүйл, үнийн судалгааг гарган сумдад хүргүүлэх ажлыг зохион байгуулах	2022-10-01	БОАЖГ	БОАЖГ, Сум дундын ойн ангиуд	-	Сумдад Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр зохион байгуулахад шаардагдах тарьц суулгацын талаар мэдээлэлтэй болно.
3	Уулнаас шилжүүлэн суулгах тохиолдолд БОАЖСайдын 2020 оны А/176 тушаалын дагуу экологи-Эдийн засгийн үнэлгээг тооцон зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах	2022-10-01 2022-10-08	Сумдын ЗДТГ	БОАЖГ, Сум дундын ойн ангиуд	-	БОАЖСайдын тушаал хэрэгжсэн байна.
4	"Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийг "Мод тарьж ногоон суварга босгоё" аяны хүрээнд уялдуулан орон нутагтаа ажлын	2022-10-01 2022-10-08	Сумдын ЗДТГ	БОАЖГ, Сум дундын ойн ангиуд	-	"Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр", сумдын 20 сая мод ургуулах 2022 оны төлөвлөгөө хэрэгжсэн байна.

	хэсэг байгуулан төлөвлөгөө гарган зохион байгуулах					
5	Орчныхоо ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, мод бут тарих ажилд иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг идэвх санаачлагатай оролцуулж, **"1өрх-5мод"** уриалгыг хэрэгжүүлэх,	2022-09-25 2022-10-08	Сумдын ЗДТГ	Сумдын ЗДТГ, Сум дундын ойн ангиуд	-	Мод, бут тарих ажилд идэвхи санаачлагатай оролцдог, ногоон байгууламж бий болгосон иргэн, ААНБ-уудыг сурталчлах, тэдэнд дэмжлэг үзүүлэх боломж бүрдэнэ.
6	Мод тарьж ургуулах, түүний ач холбогдолын талаар мэдээ мэдээлэл, гарын авлага бэлтгэн тараах, цахим хэлбэрээр олон нийтэд сурталчлах	2022-10-01 2022-10-08	Сумдын ЗДТГ	БОАЖГ, Сум дундын ойн ангиуд, Сумдын ЗДТГ, орон нутгийн сонин,ТВ-үүд,	-	Иргэд, ААНБ, өсвөр үе, ЕБС-ийн сурагчид мод тарих, арчлах хамгаалах талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй болсон байна.
7	Мод тарих өдрүүдэд иргэдэд хар шороо, өтөг бууц авчирч худалдаалах ажлыг зохион байгуулах, мэдээлэл хүргэх	2022.10.07 2022.10.08	Мөрөн сумын ЗДТГ	Хот тохижилт үйлчилгээний төв	-	Хар шороо авах цэгийг зааж өгөн иргэд мэдээлэл авсан байна.
8	Мод тарих талбайд байгууллагуудаар мод тариулах хуваарь гаргах, мэдээлэл хүргэх	2022.10.01 2022.10.08	БОАЖГазар	Мөрөн сумын ЗДТГ, ХТҮТ	-	Албан байгууллагуудын мод тарих ажил зохион байгуулагдсан байна.
9	Мод тарих, арчилж ургуулах талаар иргэн, ААНБ-уудыг мэргэжил арга зүй, мэдээллээр хангах, нийтийг хамарсан мод тарих, арчлах ажилд багш, сурагчдыг өргөнөөр оролцуулах арга хэмжээг зохион байгуулах	2022-10-08	Сумдын ЗДТГ	СДОА , Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасаг,	-	Иргэд, ААНБ, өсвөр үе, ЕБС-ийн сурагчид мод тарих, арчлах хамгаалах талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй болсон байна.
10	Мод тарих ажилд оролцох боломжгүй иргэн, ААНБ-уудаас Ойн тухай хуулийн 31 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын 2012 оны 52 дугаар тогтоолын дагуу мод тарих ажлын зардлын хандив цуглуулах, цугларсан хөрөнгөөр мод тарих	2022-10-01 2022-10-08	Сумын Засаг дарга	СДОА, Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасаг,	-	Мод тарих, хамгаалах ажлууд тодорхой болно.

	ажлыг мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авах					
11	"Тэр бум мод" үндэсний хөдөлгөөн, "Мод тарьж ногоон суварга босгоё" аяны хүрээнд мод тарьж ургуулах, эзэмшлийн ойн санг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг өөрсдийн хүч хөрөнгөөр хэрэгжүүлж үр дүнд хүрсэн иргэн, нөхөрлөл, ААНБ-ын урамшуулах болзолт ураалдааны удирдамжийн дагуу "Бүх нийтээр мод тарих өдрийн" хүрээнд сумдын хийсэн ажлын тайланг авч шалгаруулан шагнаж урамшуулах	2022-10-01 2022-11-01	БОАЖГ, Ажлын хэсэг	БОАЖГ, сумдын ЗДТГ, СДОА,	4.4	Тус аяныг орон нутагтаа идэвх санаачлагатай зохион байгуулсан сумдыг урамшуулсан байна.
Хоёр. Тарьц суулгацны үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажил						
1	Тарьц, суулгацын худалдаа явуулах талбайн схем зургийг гаргаж, худалдаа хийх иргэн, ААНБ-ийн байршлыг зааж өгөх	2022.10.07 2022.10.08	Мөрөн сумын ЗДТГ	БОАЖГ, Мөрөн сумын ЗДТГ	-	Тарьц суулгац худалдан борлуулах иргэн, ААНБ-ын байршил тодорхой болсон байна.
2	Мод худалдаалах иргэн, ААН-ийг бүртгэлжүүлж, цагийн хуваарь хэрэгжилтийг хангуулах	2022.10.07 2022.10.08	БОАЖГ	БОАЖГ, Мөрөн сумын ЗДТГ	-	Цагийн хуваарийн дагуу ажил зохион байгуулагдсан байна.
3	"Мод тарьж Ногоон суварга босгоё" аян, тарьц суулгацны худалдаа, мод тарих зөвлөмж, уриалга зэрэг мэдээллийг тогтмол байгууллагын пэйж хуудсаар дамжуулан түгээх	2022.10.07 2022.10.08	БОАЖГ, Ногоон суварга босгоё ажлын хэсэг	Орон нутгийн ТВ-үүд	-	Иргэд мэдээлэлээр хангагдсан байна.
4	Мөрөн сумын 13 багийн иргэд, ААНБ-д мод тарих, Ногоон суварга босгоё аянд нэгдэх талаар уриалга хүргэж,	2022.10.07 2022.10.08	БОАЖГ	БОАЖГ, Мөрөн сумын ЗДТГ, Дэлгэрмөрөн СДОА	-	Айл өрхүүд "1өрх-5мод" урилгад нэгдэж өөрсдийн хашаанд мод бут тарьсан байна.

	“1өрх-5мод” тарихыг уриалж идэвхжүүлэх					
6	Худалдаалагдаж буй тарьц, суулгацын гарал үүсэлд хяналт тавих, зөрчлийг арилгуулах	2022.10.07 2022.10.08	Аймгийн МХГ	Мөрөн сумын ЗДТГ	-	Гарсан зөрчил арилсан байна.
7	Чингүнжавын талбайд мод сөөгний худалдаа хийгдэж байгаа хэсэгт орц, гарц бүхий хөдөлгөөн зохицуулсан хаалт, хамгаалалт хийх, иргэдийн хөдөлгөөнд зохицуулалт хийх	2022.10.07 2022.10.08	Цагдаагийн газар	Мөрөн сумын ЗДТГ	-	Хөдөлгөөний зохицуулалт хийгдсэн байна.
Гурав. Мод тарих өдрийн нээлтийн үйл ажиллагаа						
1	“Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийн” нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах,	2022.10.08	БОАЖГ	Аймгийн ЗДТГ, БОАЖГ, Мөрөн сумын ЗДТГ, Мөрөн сумын Авъяас сургуулийн сурагчид, ХДТеатр	-	Төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулагдсан байна.
2	Байгууллагуудыг хуваарьтай талбайд мод тариулах, тарьсан модыг бүртгэлжүүлэх	2022.10.08	Мөрөн сумын ЗДТГ	БОАЖГ, ХТҮТ	-	Байгуулагууд хуваарьтай талбайдаа мод, бут тарьсан байна.
3	Хуваарьтай газраа модоо тарьж Мөрөн сумын ЗДТГазарт хүлээлгэн өгөх	2022.10.08	Мөрөн сумын ЗДТГ	ХТҮТ	-	
4	Таригдсан модны усалгаа, арчилгааг хийх	2022.10.08	ХТҮТ	Мөрөн сумын ЗДТГ	-	

_____oOo_____